

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2018 оны жилийн эцсийн байдлаар/**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолд тусгаснаар Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээнд Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх; Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт бүхий 17 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг 4 дүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Хүснэгт 1

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100 ¹	70 ²	40 ³	0 ⁴	(-) ⁵	
- Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ - Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ	2	17	12	3	2	0	-	88.0

¹ “үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90-100 хүртэл хувь/;

² “тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60-89 хүртэл хувь/;

³ “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31-59 хүртэл хувь/;

⁴ “үр дүнгүй” – зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь /0-30 хүртэл хувь/;

⁵ “үнэлэх боломжгүй” – зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан зэргийг баримтлан нотолсон бол.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2018 оны III улирлын байдлаар 73.5 хувьтай үнэлэгдсэн бол жилийн эцсийн байдлаар 88.0 хувьтай үнэлэгдэж 14.5 нэгж хувиар өссөн. Үүнд: 12 арга хэмжээ “үр дүнтэй”, 3 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 2 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй” арга хэмжээ байхгүй.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

Хүснэгт 2

			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар					
			БТГ	МААБХЗГ	ГТБХЗГ	ХөҮБХЗГ	ЖДҮХБХЗГ	ХҮҮБХЗГ
Үүнээс	Үүнээс	Бүгд	1	4	5	4	2	1
		100%	1	3	4	3	1	-
		70%	-	-	1	-	-	1
		40%	0	1	-	1	1	-
		0%	-	-	-	-	-	-
	Үнэлэх боломжгүй	-	-	-	-	-	-	
Үнэлгээ			100.0	85.0	94.0	92.5	70.0	70.0

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Бодлого төлөвлөлтийн газар 1 арга хэмжээг 100.0, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4 арга хэмжээг 85.0, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5 арга хэмжээг 94.0, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4 арга хэмжээг 92.5, Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 2 арга хэмжээг 70.0, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 70.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо
(салбараар, хяналтад авсан арга хэмжээ тус бүрээр)

Хүснэгт 3


№	Хариуцагч газар	№	Үйл ажиллагааны нэр	№	Шалгуур үзүүлэлт	IV улирал	
						Үнэлгээ	Дундаж
1	БТГ	1	3.1. Эрх зүй боловсруулах	10	5 баримт бичиг	100	100.0
2	МААБХЗГ, МЭҮГ, АДОБАЗ	1	2.1. Вакцинжуулалт	1	50 сая мал	100	85.0
		2	2.2.1. Цөм сүрэг хээлтүүлэгч ангилал	2	1000 мал	100	
		3	2.2.2. Эрчимжсэн МАА хөнгөлттэй зээл олгох	3	50-с цөөнгүй фермер	1000	
		4	2.3. Бэлчээр нөөц судалгаа	4	35 га	40	
3	ГТБХЗГ	1	2.4.1. Атрын III аян	5	Аяны хэрэгжилт 30%	100	94.0
		2	2.4.2. Зоорь багтаамж нэмэх	6	7 000 тн.	100	
		3	2.4.3. Усалгаатай талбай	7	3000 га.	100	
		4	2.4.4. Т/төх шинэчлэл	8	Шинэчлэл хувь-75	100	
		5	2.4.5. Өвлийн хүлэмж	9	10 га.	70	
4	ХҮҮБХЗГ	1	3.2. Эрүүл хүнс хөтөлбөр, мах-сүүний аян	11	Аяны хэрэгжилт 40%	70	70.0
5	ХөҮБХЗГ	1	3.3. “Үйлдвэржилт 21:100”	12	Хөтөлбөрийн хэрэгжилт 20%	70	92.5
		2	3.6. Ноолуур	15	Хөтөлбөрийн хэрэгжилт 40%	100	
		3	3.7.1. Төрийн худал.авалт	16	Худалдан авалт. өсөлт. хувь-10	100	

		4	3.7.2. Нэмэгдүүлэх нэр төрөл	17	Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо -10	100	
6	ЖДХБХЗГ	1	3.4. ЖДҮ төсөл зээл	13	Санхүүжүүлэх төсөл тоо-400	100	70.0
		2	3.5. “ЖДҮ...” хөтөлбөр	14	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	40	

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн хяналт-шинжилгээ, үнэлгээ эхний хагас жил - 55.3, III улирал - 73.5 хувьтай байсан бол жилийн эцсийн байдлаар 88.0 хувьтай үнэлэгдэв.

2. Жилийн эцсийн байдлаар үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн яамны дундаж үнэлгээ 88.0 хувь. Бодлого, төлөвлөлтийн газар, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар дунджаас дээгүүр, МААБХЗГ дунджаас 3 хувь нэгж бага байсан бол бусад газар дунджаас доогуур байв.



3. Улсын төсвийн хөрөнгөнөөс 190.0, гадаадын хөрөнгө оруулалтаар 106.0, хувийн хөрөнгө оруулалтаар 2.0, нийт 298.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Нийт төсөвлөсөн хөрөнгөөс 171.1 тэрбум төгрөг зарцуулсан буюу 57.4 хувийн санхүүжилттэй. Хөрөнгө оруулалтын зарцуулалтыг №4 дүгээр хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4

№	Хөрөнгийн төрөл	Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ, тэрбум төг.	Зарцуулалт, тэрбум төг.	Санхүүжилтэд эзлэх хувь, %	Гүйцэтгэлийн хувь, %
1	Улсын төсөв	190.0	160.3	92.9	84.4
2	Гадаадын эх үүсвэр (2.4.3; 3.3)	106.0	8.1	4.7	7.6
3	Хувийн хөрөнгө оруулалт (2.5)	2.0	4.2	2.4	210
	Дүн	298.0	172.6		

УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулахаар баталсан улсын төсвийн хөрөнгөнөөс 84.4 хувийн, гадаадын хөрөнгө оруулалтын 7.6 хувийн санхүүжилт авсан байна.

Нийт хөрөнгийн 92.8 хувийг улсын төсвөөс, 4.8 хувийг гадаадын эх үүсвэр санхүүжилсэн бол 2.4-ийг хувийн хөрөнгө оруулалтаас оруулжээ.

3.3. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд 100 тэрбум төгрөг гадаадын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан боловч санхүүжилт тасарсан байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулалтыг салбараар нь харуулбал:

			<i>Хүснэгт №5</i>
№	Салбар	Зарцуулсан хөрөнгө, тэрбум төгрөг	Эзлэх хувь, %
1	Мал аж ахуй, мал эмнэлэг	37.7	21.8
2	Газар тариалан	34.0	19.7
3	Хүнсний үйлдвэр	0.713	0.4
4	Хөнгөн үйлдвэр	0.27	0.15
5	Жижиг дунд үйлдвэр	100.0	58.4

ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулахаар баталсан хөрөнгийн 58.4 хувь буюу 100.0 тэрбум төгрөг Жижиг дунд үйлдвэр, 21.8 хувь буюу 37.7 тэрбум төгрөг Мал аж ахуй, мал эмнэлэг, 19.7 хувь буюу 34.0 тэрбум төгрөг Газар тариалан, 0.4 хувь буюу 0.713 тэрбум төгрөг Хүнсний үйлдвэр, 0.15 хувь буюу 0.27 тэрбум төгрөг Хөнгөн үйлдвэрийн салбарт тус тус зарцуулжээ.

Хүснэгт №5-аас дүгнэхэд улсын төсвийн хөрөнгийн хуваарилалт салбар тус бүр тэгш бус байна. Жижиг дунд үйлдвэрийн салбар 58.4 тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулсан нь Хүнсний үйлдвэрийн салбарынхаас даруй 83.4 дахин их байх аж.

4. “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 үнэлгээтэй арга хэмжээний талаар:

а) 2.3. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх - 2017 онд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь дэмжээгүй асуудлыг 2018 оны үндсэн чиглэлд дахин тусгасан, *2 жил дараалан хэрэгжилт хангалтгүй.*

б) 3.5. Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлт -30 хувьд хүргэх арга хэмжээ - "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан"-гийн үйл ажиллагаатай холбогдуулан улс төрийн шалтгаантайгаар хөтөлбөр батлагдаагүй, Сангийн яамнаас буцаагдаж, хэрэгжилт хангалтгүй.

в) 3.2.“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах – 2017-2018 онд үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулалт удааширсан, улмаар Сангийн яамнаас буцаагдсан байдалтай. *Хөтөлбөр батлуулах ажил 2 жил дараалан хэрэгжилт хангалтгүй.*

Тав. Зөвлөмж

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд туссан ХХААХҮ-ийн салбарын дундаж үнэлгээ 88.0 хувь гарсан бөгөөд дунджаас дээгүүр үнэлэгдэн салбар хүрсэн түвшингээ бататгаж, доогуур үнэлэгдсэн салбар дүгнэлт хийж, 2019 онд үнэлгээгээ ахиулахыг зорьж ажиллахыг;

2. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөлтийг салбарын бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндэсний хөтөлбөртэй уялдуулан тэгш хуваарилах, гадаадын эс үүсвэрээс оруулах хөрөнгө оруулалтын эрсдэлийг нарийн тооцож тусгаж байхыг;

3. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хоёр жил дараалан тусгагдаад бүрэн хэрэгжээгүй байгаа эрхзүйн актыг яаралтай батлуулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө нэн даруй батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг;

4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгах ХХААХҮ-ийн салбарын зорилт, арга хэмжээний төсөл боловсруулахдаа дээр дурдсан нөхцөл байдал, эрсдэлийг тооцож тусгах, шалгуур үзүүлэлтийг засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам баримтлан ажиллахыг тус тус зөвлөж байна.

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь																		
					Төлөв /тэрбум төгрөг/	Гүйц.сэн /тэрбум төгрөг/																				
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО																										
Зорилт 2. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ.																										
1	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт МЭЕГ /Нэгтгэсэн мэргэжилтэн Б.Отгонтгох/	Малын халдварт, гоц халдварт болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Вакцинжуулалта д хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	50-аас багагүй	20.0 Улсын төсөв	Халдварт, гоц халдварт өвчний вакцины үнэ 12.08, тарилгын үйлчилгээ ний хөлс 9,0 тэрбум төгрөг, нийт 21.08 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Улсын төсөв	<table border="1"> <tr> <td>Гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 2018 онд хамруулахаар төлөвлөсөн болон хамруулсан малын тоо</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Төлөвлөгөө /сая/</td> <td>Хамруулсан /сая/</td> </tr> <tr> <td>1. Шүлхийгээс сэргийлэх вакцин</td> <td>10.0</td> <td>15.3</td> </tr> <tr> <td>2. Бог малын мялзангаас сэргийлэх вакцин</td> <td>10.0</td> <td>14.2</td> </tr> <tr> <td>3. Хонины цэцгээс сэргийлэх вакцин</td> <td>7.5</td> <td>7.2</td> </tr> <tr> <td>Нийт тоо</td> <td>27.5</td> <td>36.7</td> </tr> </table> <p>2018 онд шүлхий өвчин 13 аймгийн 56 суманд 67 тохиолдол, бог малын мялзан өвчин 3 аймгийн 4 суманд, 4 тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөнөөс гадна нэмэлтээр мэдрэмтгий мал вакцинжуулах шаардлага гарсан болно. Мал эмнэлэг, үржлийн газар нь 2018 онд “Биокомбинат” ТӨААТҮГ-тай 20 нэрийн вакцин 5.4 тэрбум төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсан.</p>	Гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 2018 онд хамруулахаар төлөвлөсөн болон хамруулсан малын тоо				Төлөвлөгөө /сая/	Хамруулсан /сая/	1. Шүлхийгээс сэргийлэх вакцин	10.0	15.3	2. Бог малын мялзангаас сэргийлэх вакцин	10.0	14.2	3. Хонины цэцгээс сэргийлэх вакцин	7.5	7.2	Нийт тоо	27.5	36.7	100
Гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 2018 онд хамруулахаар төлөвлөсөн болон хамруулсан малын тоо																										
	Төлөвлөгөө /сая/	Хамруулсан /сая/																								
1. Шүлхийгээс сэргийлэх вакцин	10.0	15.3																								
2. Бог малын мялзангаас сэргийлэх вакцин	10.0	14.2																								
3. Хонины цэцгээс сэргийлэх вакцин	7.5	7.2																								
Нийт тоо	27.5	36.7																								

						Вакцины нэр	Төлөвлөгөө /сая тун/	Хамруулсан /сая толгой/		
						1. Архаг халдварт, зоонозоос сэргийлэх вакцин	19.9	17.1 /85.9%/		
						2. Бруцеллэзоос сэргийлэх вакцин	13.4	13.3 /99.5%//		
						Нийт тоо	33.3	30.4 (91.3%)		
						<p>Ингэснээр 2018 онд нийт 67.1 сая толгой малыг халдварт, гоц халдварт болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулсан байна. Хээлтүүлэгч малын бруцеллэзын шинжилгээнд 298,9 мянган толгой мал /буур, бух, хуц, ухна/ хамруулахаас 242.35 дээжийг орон нутгийн МЭАЦЛ-иудад шинжилж, баталгаажуулах шинжилгээг УМЭАЦТЛ, МЭХ, МЭС-ийн шинжээчид газар дээр нь гүйцэтгэсэн. Шинжилгээгээр буур 279/11-0,53%, бух 25453/141-0,55%, хуц 117816/396-0,34%, ухна 97030/304-0,31%-ийн халдварлалттай гарсан. Улсын хэмжээнд нийт 0,02-1,7%-ийн халдварлалттай байв. Булган, Дархан-Уул, Өвөрхангай аймаг, Улаанбаатар хотын хэмжээнд халдварлалт өндөр байна.</p>				
2	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт	Бэлчээрийн монгол малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах, өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн малын тоог нэмэгдүүлэх	Шинээр нэмэгдүүлэх үржлийн цөм сүргийн өсвөр хээлтүүлэгч, малын тоо МҮББХЗГ	1000 /1500/	0.3 Улсын төсөв	0.270	<p>“Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх” тухай ХХААХҮ-ийн Сайдын 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-69 дүгээр тушаалаар 16 аймгийн 54 сумын 369,1 мянган малд үзлэг ангилалт хийх гэрээг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав. Үзлэг ангилалтанд 310,5 мянган бог, 64,4 мянган бод, нийт 374,9 мянган мал хамрагдаж, гүйцэтгэл 102 хувьтай байна. Ангилалтанд хамрагдсан нийт малын 80,3 мянга буюу 21,4% цөм, 191,9 мянга буюу 51,2%</p>		100	

							үржлийн, 102,5 мянга буюу 27,3% хэрэгцээний сүрэгт хамрагдсан байна. Ангилалтанд хамрагдсан 17,8 мянган бог малын хээлтүүлэгчийн 6,6 мянга буюу 37,3% нь цөм сүргийн шаардлага хангасан бөгөөд 2,5 мянган өсвөр хээлтүүлэгчийг бойжуулж, бойжилтын явцад стандартын шаардлага хангасан 1,5 мянган хээлтүүлэгчийг Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлж ажилласан.	
3			Хөнгөлөлттэй зээл авах фермерийн аж ахуйн нэгжийн тоо МААБХЗГ	50-аас багагүй /74 ААН/	2.0 Улсын төсөв	0.509 1.0 14.11 Нийт 15.6	Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулах ажлын хүрээнд 39 төслийг үнэлж, ХХААХҮ-н сайдын 2018 оны А-163 дугаар тушаалаар 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3.6 хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэн хэрэгжилтийг зохион байгуулав. Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдэрлэл нэмэгдүүлэх зорилгоор "Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх" төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосноор энэ онд тэжээлийн ургамал тариалалт 1000 га-гаар нэмэгдүүлэв. ЖДҮХС-аас төслийн шаардлага хангасан мах, сүүний үхрийн фермерийн 30 аж ахуйн нэгжид 14.1 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.	100
4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36, 2.38 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх МААБХЗГ	Отрын бүс нутгийн судалгаанд хамрагдах талбайн хэмжээ, га	35.0	0.05 Улсын төсөв	0	Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутгийн судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсэг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт 87.0 мянган га бэлчээрт судалгаа хийж сумын удирдлагуудад танилцуулснаар холбогдох багийн ИНХ болон сумын ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан, холбогдох тогтоолуудыг ирүүлсэн. Цэцэрлэг сумын Зуун мод багийн иргэдийн Нийтийн Хурлын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар	40

						тогтоолоор аймаг дундын отрын бүс нутаг байгуулах асуудлыг дэмжсэн боловч сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 08 дугаар тогтоолоор дэмжигдээгүй. Иймээс энэ асуудлыг холбогдох төлөвлөгөөний биелэлтээс хасуулахаар санал өгсөн. “Ногоон алт малын эрүүл мэнд” төсөл нь МААБХЗГ хамтран ажилласны үр дүнд улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын Аргалант, Багахайрхан, Малахын отрын бүс нутгуудын бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг хийж гүйцэтгэсэн.		
5	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.39-2.47, ЭЗСХ-ийн 2.1.8 дахь заалт	Атрын III аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх ГТБХЗГ	Аяны хэрэгжилт, хувиар	30.0	20.0 Улсын төсөв	Урамшуулал-14.8 (Мөнгөн хэлбэр-7.0 Мөнгөн бус 7.8) Буудайн Үр-4.0 тэрбум Техник-334,0 сая төгрөг, Жимс, жимсгэнэ хөтөлбөр-1.0 тэрбум, Хүнсний ногоо хөтөлбөр – 1.0 тэрбум төгрөг Нийт 21.1 тэрбум төгрөг	Атрын III аяныг үргэлжлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр ЗГ-ын шийдвэрээр ой угтсан “Атар-60” бүтээлч ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Тус төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаар гарган ХШҮ хийж ... хувиар дүгнэв. Тариалалтад зориулан 8.0 мянган тонн чанар сайтай элит болон сортын үрийн буудайг импортлон, шаардагдах 60.0 мян.тн үрийн нөөцийг 100 хувь бүрдүүлэв. ЗГ-ын шийдвэрийн дагуу тариалалтад олгох үрийн үнэнд хөнгөлөлт үзүүлж импортын I үржүүлгийн болон элит үрийг 620.0-660.0, дотоодын ургацаас нөөц бүрдүүлсэн сортын үрийг 570.0 мян.төг-өөр тус тус тогтоож тариаланчдад 10-30 хувийн урьдчилгаатай зээлээр олгож намрын ургацаас нөхөн бүрдүүлэхээр шийдвэрлэн 611 аж ахуйн нэгж, иргэнд 30.5 мянган тонн буудайн үр олгов. 2018 оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр нийтдээ 444.7 мянган тонн үр тариа, үүнээс 428.6 мянган тонн улаанбуудай, 167.9 мянган тонн төмс, 99.2 мянган тонн хүнсний ногоо, 23.4 мянган тонн тосны ургамал, 134.3 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч буудай, төмсний хэрэгцээг дотоодын ургацаас бүрэн хангах боломжийг бүрдүүлэв.	100

6			Зоорийн багтаамжийн нэмэгдэх хэмжээ, тн	7000 /14000тн/		0.600	ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-30 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд 200 тн зоорийг “Дострой” ХХК-тай гэрээ байгуулан 100.0 сая төгрөгөөр, Ховд аймгийн Жаргалант суманд “МГБИ” ХХК-тай гэрээ байгуулан 1000 тн зоорийг 400.0 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэсэн. Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас Жавхлант суманд 100 тн зоорийг 100.0 сая төгрөгөөр нийт 1200 тн хүнсний ногооны зоорь байгуулахаар шийдвэрлэж хэрэгжилтийг зохион байгуулсан. Ховд аймгийн Жаргалант суманд байгуулж буй зоорийг 2019 онд ашиглалтад оруулна. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зоорь байгуулахаар хөнгөлөлттэй зээл авсан “Органик солюшнс” ХХК СХД-т 14.0 мянган тонн багтаамжтай төмс хүнсний ногооны хагас автомат удирдлагатай, механикжсан зоорийг 2018 онд ашиглалтад оруулсан. Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт “ХБХДТ” ХХК шалгарч гэрээ байгуулан, зөвлөх үйлчилгээг ХХААХҮЯ-ны ажлыг хэсэг хүлээн авч, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар хүлээлгэн өгсөн.	100
7			Усалгаатай талбайг нэмэгдүүлэх хэмжээ, га	3000 /5300/		0	БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр усалгааны тоног төхөөрөмж, хоолойг нийлүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд үр тариа, төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээ 9000 га-аар нэмэгдэж, усалгаатай талбайн ашиглалт сайжрах боломж бүрдэнэ. Усалгааны тоног төхөөрөмж худалдан авах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэд, хоршоонд лизингээр олгохоор төлөвлөж байна. Баян-Өлгий аймгийн Алтай сумын 22.0 га талбайг услах услалтын систем байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Нар маржан” ХХК,	100

							Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын “Тээлийн ам”-ын 95 га талбайн услалтын системийг барих ажлын гүйцэтгэгчээр “Туурайн тамга” ХХК тус тус шалгарч барилгын ажлыг гүйцэтгэж хүлээлгэж өгсөн. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 5.3 мянган га талбайг усалгаатай тариалангийн талбайн эргэлтэд нэмж оруулах боломж бүрдсэн.	
8			Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь	75.0	6.0 Гадаад эх үүсвэр	8.1	Монгол Улсын Хөгжлийн банкны “Ди Би Эм Лизинг” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн Газар тариалангийн техникийн шинэчлэл төслийн хүрээнд ОХУ-ын “Внешэконом” банкны 2.7 сая еврогийн зээлийн хөрөнгөөр 30ш үр тариа хураах комбайн нийлүүлэгдэж ТЭДС-аар дамжуулан тариалан эрхлэгч аж ахуйн нэгжид 30 хувийн урьчилгаа төлбөртэй 4 жилийн хугацаатай лизингээр олгох ажлыг зохион байгуулав. Дээрх техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр 17.0 мянган га талбайн үр тариаг технологийн хугацаанд хураах техник үйлдвэрлэлд шинээр нэвтэрч үр тариа хураах комбайны шинэчлэл 77 хувьд хүрэв.	100
9	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44, ЭЗСХ-ийн 2.1.13 дахь заалт	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах ГТБХЗГ	Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, га	10 /7 га/	2.0 Хувийн хөрөнгө оруулалт	4,2 Хувийн хэвшлийн 10 гаруй тэрбум	20 га талбай бүхий “Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл болон өвлийн хүлэмжийн аж ахуйд хэрэглэсэн цахилгааны төлбөрөөс жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд оройн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд 1 м2 талбайд 0.762 кв/цаг-аар тооцож 100 хувь чөлөөлөх шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолоор батлуулж өвлийн хүлэмжийн аж ахуй хөгжих, жилийн турш хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлэв. Улсын төсвийн санхүүжилтээр 32 м2 талбай бүхий 160 ширхэг нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулалт зохион байгуулж ТНБД-ын А/-600 дугаар тушаалаар	70

							шалгарсан оролцогчтой гэрээ байгуулан зуны хүлэмжийн үйлдвэрлэлийг 5120 м2 талбайгаар нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. 2018 онд Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 3 га талбайд өвлийн хүлэмж байгуулах 12 иргэн, аж ахуйн нэгжид 4.2 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв. Хувийн хөрөнгө оруулалтаар 3.5 га талбай бүхий өвлийн хүлэмжийг байгуулав. БНХАУ-ын Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хүлэмжийн аж ахуй байгуулах иргэн, аж ахуйн нэгжид 150,000-3,000,000 хүртэл долларын зээл олгож байна.	
--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт 3. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

10	МУТХУБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20, 2.41, 2.47, 2.48 дахь заалт	Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох БТГ, ХХ	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	5	-	0	<ul style="list-style-type: none"> - Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав. - Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав. - Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав. - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав. - Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулав. 	100
----	---	---	--	---	---	---	--	-----

							<ul style="list-style-type: none"> - “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар батлуулав. - “Малын эрүүл мэнд хөтөлбөр” Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлуулав. - “Ноолуур” хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 47 дугаар тогтоолоор батлуулав. - Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХХААХҮЯ-ны бүтцийн өөрчлөлт) Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 187 дугаар тогтоолоор батлуулсан. - “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 131 дугаар тогтоолоор батлуулсан. - 2018 онд Сайдын тушаалаар баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон 12 шийдвэрийг тухай бүр нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох хөдөлгөөн хийлгэх ажлыг зохион байгуулсан. 	
11	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах Хүнсний ҮБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	30.0 Улсын төсөв	0.713	Хөтөлбөрийн төслийг боловсруулж, хэлэлцүүлгүүд зохион байгуулж санал тусгасан бөгөөд төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Засгийн газрын 2017 оны 44 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу арилжааны банкны зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх замаар нэр бүхий 10 аж ахуйн нэгжтэй хамтран нийт 12.8 мянган тн махыг орон нутгаас бэлтгэсэн. Бэлтгэсэн махыг Улаанбаатар хот, Дархан-Уул	70

						<p>аймгийн хүн амын хэрэгцээнд зориулан 2018 оны 4-7 дугаар сард зах зээлийн үнээс 13-30 хувиар хямд нийлүүлсэн.</p> <p>Орон нутгийн сүүний нөөцийг ашиглан импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор “MDM” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Монгол хуурай сүү” төслийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд 2018 онд 6 үйлдвэр ашиглалтад орсон. Орон нутагт 10 суманд үйлдвэр ашиглалтад оруулахаар дэд бүтэц, барилгын угсралтыг эхлүүлсэн.</p> <p>НҮБ-ын ХХААБ-ын төслийн дэмжлэгээр Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд өдөрт 2200 л сүү хүлээн авах төвийг 2018 оны 6-р сард ашиглалтад оруулсан.</p> <p>Сүүний салбарыг дэмжих зорилгоор сүүний хөргөлтийн танк 10 ш, цахилгаан хөдөлгөөнт 140 ш саалтуурыг сүүний үхрийн фермерүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулав.</p> <p>НҮБ-ын ХХААБ-тай хамтран “Дэлхийн сүүний өдөр”-ийг тэмдэглэх ажлыг 2018 оны 6-р сарын 01-нд зохион байгуулж, салбарын ололт амжилтыг сурталчлав. Мөн “Dairy Asia” индэрийн үндэсний зохицуулагч, Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлыг Энэтхэг, Бангладеш, Вьетнам, Тайланд, Бутан, Непал, Шри Ланка зэрэг 10 гаруй орны төлөөлөгчтэй 2018 оны 6-р сарын 10-11-нд Улаанбаатар хотод зохион байгуулав.</p> <p>Хүүхдийн сүүний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж, шалгасан аж ахуйн нэгжийн боловсруулсан ТЭЗҮ-г хүлээж авав.</p> <p>Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид</p>
--	--	--	--	--	--	---

							мөнгөн урамшуулал олгох санал, тооцоог боловсруулж, 2019 оны улсын төсөвт 13.5 тэрбум төгрөг тусгуулахаар СЯ-нд хүргүүлсэн. /Монгол Улсын 2019 оны төсөвт 4 тэрбум төгрөг тусгагдсан/.																																					
12	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.48 дахь заалт	Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	100.0 Гадаад эх үүсвэр	0,214	–“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 36 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан бөгөөд 2018 онд хэрэгжүүлэх 44 арга хэмжээний хэрэгжилт 67.7 хувьтай үнэлэгдлээ. Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлэв.	70																																				
13	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих ЖДҮХБХЗГ	Санхүүжүүлэх төслийн тоо	400	20.0 Улсын төсөв	99.9	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэнд 2018 онд 97.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдаж, 2 удаагийн төсөл сонгон шалгаруулалтад нийт 1542 иргэн, аж ахуйн нэгжийн 1,58 их наяд төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл ирүүлснээс журмын шаардлага хангасан 212 төслийг шалгаруулж, 96.4 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:	100																																				
							<table border="1"> <thead> <tr> <th>Чиглэл</th> <th>ААН-ийн тоо</th> <th>Зээл, тэрбум₮</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Барилгын материал</td> <td>27</td> <td>15.1</td> </tr> <tr> <td>био бэлдмэл</td> <td>5</td> <td>3.6</td> </tr> <tr> <td>газар тариалан</td> <td>29</td> <td>15.0</td> </tr> <tr> <td>зоорь</td> <td>10</td> <td>4.1</td> </tr> <tr> <td>МАА</td> <td>30</td> <td>13.5</td> </tr> <tr> <td>хөнгөн үйл.</td> <td>37</td> <td>10.3</td> </tr> <tr> <td>худалдаа үйлчилгээ</td> <td>15</td> <td>7.9</td> </tr> <tr> <td>хүнс үйл.</td> <td>54</td> <td>24.7</td> </tr> <tr> <td>боловсруулах</td> <td>3</td> <td>1,3</td> </tr> <tr> <td>Дахивар</td> <td>2</td> <td>0.7</td> </tr> <tr> <td></td> <td>212</td> <td>96.4</td> </tr> </tbody> </table>	Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, тэрбум₮	Барилгын материал	27	15.1	био бэлдмэл	5	3.6	газар тариалан	29	15.0	зоорь	10	4.1	МАА	30	13.5	хөнгөн үйл.	37	10.3	худалдаа үйлчилгээ	15	7.9	хүнс үйл.	54	24.7	боловсруулах	3	1,3	Дахивар	2	0.7		212	96.4	
Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, тэрбум₮																																										
Барилгын материал	27	15.1																																										
био бэлдмэл	5	3.6																																										
газар тариалан	29	15.0																																										
зоорь	10	4.1																																										
МАА	30	13.5																																										
хөнгөн үйл.	37	10.3																																										
худалдаа үйлчилгээ	15	7.9																																										
хүнс үйл.	54	24.7																																										
боловсруулах	3	1,3																																										
Дахивар	2	0.7																																										
	212	96.4																																										
							Энэ онд нийт 212 төсөл санхүүжүүлсэн нь																																					

						<p>өмнөх онтой харьцуулахад 62 төслөөр илүү болж, хүртээмжийг нэмэгдүүлсэн. МХС-аас олгосон зээл</p> <table border="1"> <thead> <tr> <th>Чиглэл</th> <th>ААН-ийн тоо</th> <th>Зээл, /сая.төг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Уурагт гэжээл тарих</td> <td>17</td> <td>999.6</td> </tr> <tr> <td>Зөгийн үржүүлэг</td> <td>7</td> <td>35.0</td> </tr> <tr> <td>МҮААН</td> <td>8</td> <td>185.0</td> </tr> <tr> <td>Дүн</td> <td>32</td> <td>1,219.6</td> </tr> </tbody> </table> <p>Зээлийн үр дүнд шинээр 613 ажлын байр бий болж 1489 ажлын байр хадгалагдана. Сум хөгжүүлэх сангаас 2018 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2198 иргэн, аж ахуйн нэгжид 13,598 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд 2747 шинэ ажлын байр бий болгосон байна. Улсын хэмжээнд ЖДҮХС болон сум хөгжүүлэх сангаас нийт 2414 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг 112878,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр дэмжин 3360 ажлын байр шинээр бий болгосон.</p>	Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, /сая.төг/	Уурагт гэжээл тарих	17	999.6	Зөгийн үржүүлэг	7	35.0	МҮААН	8	185.0	Дүн	32	1,219.6	
Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, /сая.төг/																				
Уурагт гэжээл тарих	17	999.6																				
Зөгийн үржүүлэг	7	35.0																				
МҮААН	8	185.0																				
Дүн	32	1,219.6																				
14	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ЖДҮХБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	100.0	0,04	"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн төсөлд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн, яамдаас ирсэн санал болон 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусгаж, Сангийн яамнаас зөвшөөрөл авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Сангийн яаманд зөвшөөрөл авахаар 3 удаа 2017 оны 12 сар, 2018 оны 04, 08, 10 дугаар сард тус тус хандсан боловч төсвийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг хүлээн зөвшөөрөөгүй, хүлээгдэж байна.	40														

15	ЗГҮАХ-ийн 2.51 дэх заалт	“Монгол ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	-	0.05	<p>“Ноолуур” хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн, 2018 оны хэрэгжилт 87.1 хувиар үнэлэгдлээ. Гарсан үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэн, МУХБ-ны эх үүсвэрээс үйлдвэрлэгчдэд зээл олгохоор “Ноолуур” хөтөлбөрийн зээлийн нөхцөл тохирох гэрээ байгуулж, нийт 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон. Эдгээр үйлдвэрийн түүхий ноолуурын бэлтгэл өмнөх оноос 531.1 тн, самнасан ноолуур 125.2 тн-оор өссөн. Самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8%, ээрэх 28.6%, сүлжих 42.7%-иар өсч, ажлын байр 1571-ээр нэмэгджээ. -Түүхий эдийн боловсруулалтын төвшнөөс хамааруулан ХААБ-ийн шимтгэл 0.32% байсныг угаасан ноолуурт 1%, самнасан ноолуурт 0.2% болгон өөрчилснөөр 2017 онтой харьцуулахад угаасан ноолуурын экспорт 2.5%--иар буурч, самнасан ноолуурын экспорт 13%--иар өссөн. Түүхий эдийн чанар, хадгалалт, хүлээн авалтыг сайжруулах зорилгоор ОУ-ын төслийн санхүүжилтээр 4 аймагт нийт 10 түүхий эдийн агуулахыг энэ ондоо багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. - Япон, АНУ-ын олон улсын үзэсгэлэнд 30-аад компани оролцож, эдгээр улсад гаргасан экспортын хэмжээ өмнөх оноос 20-30% нэмэгдсэн. -Дотооддоо “Монгол экспорт экспо”-г зохион байгуулж, үзэсгэлэнд 40 гаруй үйлдвэр оролцож 180 сая төгрөгийн борлуулалт хийв. -ХХААХҮЯ-ны эзэмшдэг “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр 181018/06-400 тоот гэрээг МННХ-той байгуулсан. 	100
----	-----------------------------	--	-------------------------------------	------	---	------	---	-----

							-Олон улсын чанарын “Oeko-Tech 100” сертификатын шалгуурыг 2 үйлдвэр хангаж, ээрмэл утсандаа тус сертификатыг авснаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлсэн. -Экспортыг дэмжих төсөл, ШУТИС-ийн “Shima Seiki Training center” сургалтын төв, Японы Shima Seiki фирмийн “Total Design Center” төвтэй хамтран сүлжмэлийн АРЕХ- 3 дизайн системийн ахисан түвшний сургалтад 20 гаруй үйлдвэрийн 50 дизайнерууд хамрагдсанаар Японд олгодог сертификатыг Монголдоо авсан. Дэлгэрэнгүйг хавсралтаар хүргүүлэв.	
16	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт	Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх ЖДҮХБХЗГ	Худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-	0,01	2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 56 төсвийн ерөнхийлөн захирагчид болон 45 төрийн өмчийн оролцоотой компаний худалдан авалт 210 тэрбум төгрөгт хүрч, урьдчилсан гүйцэтгэлээр худалдан авалт 12%-иар нэмэгдсэн байна. Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” батлагдаж, 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ журмын 2.3-т Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багц болгоно гэж заасан нь дотоодын үйлдвэрлэгчид тендерт оролцох өргөн боломжийг нээж, импортын бараанаас тусад нь багц үүсгэн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар бууруулж тендерийн үнийг харьцуулж байна.	100
17			Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо	10.0	-	0	-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан нийт бараа, бүтээгдэхүүний худалдан авалтын тайлан мэдээг нэгтгэв. Үүнд: 2017 онд ТЕЗ 45 байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд 25, нийт 70 байгууллагын худалдан авалтын тайланд дүгнэлт хийхэд нийт	100

						<p>275 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дотоодын үйлдвэрээс худалдан авсан байгаа нь өмнөх оны тайланд тусгасан 12 бүлгийн 101 төрлийн бараа бүтээгдэхүүнээс даруй 30 гаруй нэр төрлөөр давсан үзүүлэлттэй байна.</p> <p>2018 оны 10-р сарын 10-ны өдрийн байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагчид болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд нийт 9811 тендер зарлаж, тендерийг эдийн засгийн 97 ангиллаар ангилахад эрүүл мэндийн үйл ажиллагаа 12, барилга угсралт 8.7, батлан хамгаалах үйл ажиллагаа 7.8 тэрбум, уул уурхай, олборлолтын туслах үйл ажиллагаа 5.1 тэрбум, цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний 4.3 тэрбум төгрөгийн гэрээ тус тус байгуулсан.</p> <p>Энэхүү тайланд үндэслэн “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ын 6 бүлэг, 10 гаруй нэр төрөлд нэмэлт өөрчлөлт оруулах, тухайлбал мод, модон бүтээгдэхүүн, зам барилгын материал, төмөр хийц, бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, Бусад бүтээгдэхүүн болон шинээр тоног төхөөрөмж гэсэн ангиллыг нэмж оруулсан тогтоолын төслийг боловсруулан холбогдох байгууллагаас санал авах болон Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дотоодын эрэлт хэрэгцээнд нийцсэн, үйлдвэрлэлийн бодит хүчин чадалд суурилсан, чанар стандартын шаардлагад нийцсэн байх зэрэг шалгуур тавин ажиллаж байна.</p>	
							88.0